



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаан хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдааныг 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09⁰⁰ цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтсугай.

Үүнд:

- 1) Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийг дүгнэж, 2016 оны зорилт батлах тухай
/Илтгэгч: Дүүргийн Засаг дарга Д.Ганболд/
- 2) Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр/
- 3) Дүүргийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах, 2016 оны төсөв батлах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр/
- 4) Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай
/Илтгэгч нь: Дүүргийн Өмч, газрын харилцааны албаны дарга М.Алтансүх/
- 5) Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга
/Илтгэгч нь: Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Ц.Алтанцацрал/

2. Хуралдаанд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

3. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, дүүргийн Засаг даргын Тамгын газар/Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



1150100137



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын хороодыг хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Хурлын хороодыг хуралдуулсугай.
2. Хурлын хороодын хуралдааны удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.
3. Хороодын хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Хурлын хороодын дарга нарт даалгасугай.
4. Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, техник зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, дүүргийн Засаг даргын Тамгын газар /Ж.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100138

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 сарын
26-ны өдрийн 66 дугаар тогтоолын хавсралт



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын хороодын ажиллах удирдамж

Нэг. Хурлын хороод нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанаар хэлэлцэгдэх дараах асуудлуудыг урьдчилан бэлтгэж, санал дүгнэлт боловсруулна. Үүнд:

1. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны зорилтын төсөл
2. Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл
3. Дүүргийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах, 2016 оны төсвийн төсөл
4. Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны төлөвлөгөөний төсөл

Хоёр. Хурлын хороод танилцсан ажлын чиглэлээр гаргасан саналаа Хурлын Ажлын албанд ирүүлнэ. Засаг даргын Тамгын газар хороодоос ирүүлсэн саналуудыг төсөлд тусгасан эсэх талаар Хурлын хороодод тухай бүрт нь албан бичгээр хүргүүлж ажиллана.

Гурав. Хурлын хороод хэлэлцсэн асуудлаар дүгнэлт боловсруулан 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан, 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит наймдугаар хуралдаанд тус тус танилцуулна.

Дөрөв. Хурлын хороод ажиллахад шаардагдах зардлыг /тээвэр, шатахуун, баримт материал олшруулах, хэвлэх/ Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Тав. Хурлын хороодын ажиллах хуваарь:

№	Хурлын хороод	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцсан хорооны дарга, Нарийн бичиг	Хариуцсан хэлтэс, алба
1.	Байгаль орчин, экологийн асуудал эрхэлсэн хороо	- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны нийгэм, эдийн засгийн зорилтын төсөл /харъяалах асуудлаар/	2015.12.09 10 ⁰⁰	Л.Давийчомбо Б.Өнөрбат	ЗД-ын орлогч Б.Батхуяг ЗДТГ-ын дарга Ж.Эрдэнэбат ЭЗТХ-ийн дарга С.Янжинхорлоо ДБТХ-ийн дарга А.Гэрэлт-Од ӨГХА-ны дарга М.Алтансүх

		-Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл			
2	Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны нийгэм, эдийн засгийн зорилтын төсөл /харъяалах асуудлаар/	2015.12.09 14 ⁰⁰	Ү.Тэгшбаатар Б.Гүжин	ЗДТГ-ын дарга Ж.Эрдэнэбат ЭЗТХ-ийн дарга С.Янжинхорлоо НХХ-ийн дарга Я.Орломсүрэн
3	Иргэний оролцоо, санал хүсэлтийн хороо	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны нийгэм, эдийн засгийн зорилтын төсөл /харъяалах асуудлаар/	2015.12.10 10 ⁰⁰	Ч.Болормаа Ч.Энхчимэг	ЗДТГ-ын дарга Ж.Эрдэнэбат ЭЗТХ-ийн дарга С.Янжинхорлоо ЗХХ-ийн дарга А.Дамцагдорж
4	Дэд бүтэц, тохижилт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны зорилтын хэрэгжилт, 2016 оны нийгэм, эдийн засгийн зорилтын төсөл /харъяалах асуудлаар/	2015.12.10 14 ⁰⁰	Д.Алтанхуяг Н.Янжинлхам	ЗД-ын орлогч Ц.Содхүү ЗДТГ-ын дарга Ж.Эрдэнэбат ДБТХ-ийн дарга А.Гэрэлт-Од ХҮХ-ийн дарга Д.Булган ЭЗТХ-ийн дарга С.Янжинхорлоо